

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Алтанхуяг	Дугаар	L150
Оршин суугаа аймаг	Баянхонгор	Оршин суугаа сум	Хүрээмарал
Төрсөн газар		Төрсөн он	
Ажил мэргэжил	Унзад лам		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Цоржийн хүрээ	Сүм хийдийн дугаар	БХХМ 076
Одоогийн сүм хийд	Дашдаржаалин хийд	Сүм хийдийн дугаар	БХХМ 015
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 8-р сарын 12	Ярилцлага авсан хүн	Мөнхнасан



Баянхонгор аймгийн Хүрээмарал сумын **Дашдаржаалан** хийд, Цоржийн хүрээ

Асуулт:-Ингээд та хуучин энэ сумын нутагт байсан Цоржийн хүрээний тухай ярьж өгнө үү. Анх хэдэн онд ямар хүний зарлигаар ч гэдэг юмуу байгуулагдсан юм бэ?

Хариулт:-Сайн мэдэхгүй юмаа. 16 он гэж ярьдаг байхаар Үхэр жилийн хавар их багш тухайн үедээ хааны багш гэж яригдаж байсан Юндэндорж гэж хүний тааллаар гэх юмуу даа Тавнан Дашзэвэг гэж хүн байгуулж байсан юм гэнэ лээ. Тавнан гэдэг нь цол нь. Тухайн үедээ хошуу захирагч байсан гэдэг юм. Тэгээд тэр хүн байгуулаад тэгээд их багшийг Гурванбулагийн **Хар усан** гэдэг газар шавь нартайгаа ирчихсэн байж байхад нь тэр хүнийг нааш нь залаад тэгээд 13 жил болсон гэдэг юм. 13 жил болохдоо 13 зиндаагаар **Чойрын** ном үзэж, халхад нэлээн **цууд** мандаж байсан. Гэвшийн дамжаа барьж байсан. **Ралаансалжид** гэдэг номыг үздэг байсан гэж ярьдаг юм, хамгийн сүүлд.

Асуулт:-Аль **игчаагаар** үздэг байсан юм бэ?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Хариулт:-**Гүнчин игчаа** гэж. Архангайн Тариат, Хөвсгөл аймгийн, Завханы Яруу, Нөмрөг гэж бас сайхан алдартай хийдүүд байсан, тэндээс хүртэл сайчуул ирж ном эрдмийг нь дээшлүүлж байсан гэж ярьдаг юм.

Асуулт:-Энэ хийдийн барилгыг нь юугаар барьсан байсан юм бол?

Хариулт:-Тэрнийг мэдэхгүй юм.

Асуулт:-Хэдэн оны үед байхгүй болсон юм бол?

Хариулт:-37 онд нурсан юм шиг байгаа юм.

Асуулт:-Хийдийн лам нарыг яасан юм бол?

Хариулт:-Лам нар нь хэлмэгдэлд нэлээн өртсөн гэдэг юм, барьж аваад явчихсан.

Асуулт:-Сүм хийд, бурхан шүтээн, ном судар?

Хариулт:-Тэрнийг мэдэх юм байхгүй. Одоогоор тийм юм үлдсэн, өвлөгдсөн тийм зүйл ерөөсөө байдаггүй.

Асуулт:-Та энэ хийдийнхээ тухай ярьж өгөхгүй юу?

Хариулт:-Энэ хийд бол гэвш **Лхамжавсүрэн** гэж тэр Чойжийн хүрээнд сууж байсан тийм гэлэн хүн байсан. Тэр хүний зиндааны улсууд гэх юм бол Улаанбаатар хотод Лхасүрэн гэж хүн байсан, Сэдбазар гуай гэж хүн байсан. Тэд нарын зиндааны хүн байсан. Гэвш хүн байсан. Тэр хүний зарлигаар энийг 1990 онд байгуулагдсан. Тэгээд **сургалтанд** хүүхдүүд аваад **тэрэн** дээр их олон лам нар байсан, хөгшчүүл бас нэлээн байсан. **О.**Найдан, хоёр ч Найдан гэж лам байсан. Балжинням гэж багш байсан. **Лхамжавсүрэн** гэж лам байлаа. Лхамрагчаа гэж лам байлаа.

Асуулт:-Танай хийдээс шашны дээд сургууль, Энэтхэг, Төвдөд лам нар сурч байна уу?

Хариулт:-Энэтхэгт 1 хүүхэд сурч байна, **Дашчоймболд** 1 хүүхэд байна, Зүүн хүрээ Дашчойлон хийдэд 1 багшилж байна, 1 нь унзад хийж байна. Суралцаж байгаа хүүхдүүд төгсөх дамжааны 2 байна, наана нь тэр ангиудад 3 хүүхэд байна.

Асуулт:-Одоо энд хэдэн лам хурал номоо хүрж байна?

Хариулт:-Одоогийн байдлаар 16 лам байна.

Асуулт:-Өдөр тутам хүрж байна уу? **Мацагууддаа** хүрж байна уу?

Хариулт:-**Мацагууддаа** хүрж байна.

Асуулт:-Уул хангайгаа тахиж байна уу?

Хариулт:-Мандал хайрхан гэж энэ шүтээн байна, тахилгатай уул байна. **Баян нуруу** гэж Цагаан хайрхан гэж бий, энэ хоёрыгоо л тахиж байна.

Асуулт:-Хэдэн сарын үед тахиж вэ?

Хариулт:-Зуны эхэн сард л

Асуулт:-Цагаан идээгээр тахиж уу?

Хариулт:-Тийм, цагаан идээгээр тахина.

Асуулт:-Хуучин Чойжин хүрээний лам нар аль уулаа тахидаг байсан бэ?

Хариулт:-Энэ хоёрыг.